

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, тус хуулийн 5 дугаар зүйлд 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ялыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр заасан.

Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд зорчих эрхийг хязгаарлах ялын шинэ төрлийг нэмж, уг ялыг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар хуульчилж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэм, хамт олноос нь тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Уг ялыг хэрэгжүүлэхэд цахим хяналтын төхөөрөмж ашиглаж хяналт тавихаар төлөвлөж “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг 9.5 сая ам долларын санхүүжилтээр байгуулах эдийн засгийн тооцоо, судалгаа гарч Бүгд Найрамдах Солонгос Улсын “Эксим” банкны хөнгөлөлттэй зээлд хамруулахаар шийдвэрлэсны дагуу тус төвийг байгуулах төслийг тус улсаас тавьсан шаардлагын дагуу 9 үе шаттайгаар боловсруулж техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн хамтаар хүргүүлсэн бөгөөд “Эксим” банкнаас “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг байгуулах төслийн төсвийн өртгийг 9.5 сая байсныг 16.148.051 сая ам доллар болгохоор санал ирүүлснийг 10.450.000 сая ам долларт багтаан хэрэгжүүлэхээр зээлийн хүсэлтийг хүргүүлээд байна.

Түүнчлэн тус ялыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газар, Газар, зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зорчих эрхийг хязгаарлах ялыг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, хяналт тавихад шаардагдах Монгол Улсын 1:1000, 1:10000 хэмжээтэй байр зүйн зураг ашиглах зөвшөөрөл болон “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг барьж байгуулахад шаардлагатай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2 дугаар байрны 971 м² газрыг 1365 м²-аар нэмэгдүүлж холбогдох газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус авсан.

Хэдийгээр холбогдох зөвшөөрлийг авах асуудлыг тухай бүр шийдвэрлээд байгаа боловч “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг байгуулах санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй, зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах цахим бугуйвч, түүний техникийн үзүүлэлт, дагалдах тоног төхөөрөмжүүдийн төрөл тодорхой болоогүй зэрэг томоохон ажлууд хийгдээгүй байна.

Иймд хуулийн хэрэгжилттэй холбогдуулан бэлтгэл ажлыг хийх шаардлагатай байгаа тул Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж, зорчих эрхийг хязгаарлах ялын дагаж мөрдөх хугацааг хойшлуулах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж, тус хуулийн 5 дугаар зүйлд 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ялыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр заасан хугацааг хойшлуулан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж, зорчих эрхийг хязгаарлах ялын дагаж мөрдөх хугацааг хойшлуулснаар “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж тус төвийг байгуулах, зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах цахим бугуйвч, түүний техникийн үзүүлэлт, дагалдах тоног төхөөрөмжүүдийн төрлийг тодорхой болгох зэрэг бэлтгэл ажлуудыг хангаж, зорчих эрхийг хязгаарлах ялыг гүйцэтгэхэд аливаа бэрхшээл үүсэхээс сэргийлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай уялдуулан боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.